



# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу.**

ТАБ-ын Дарга, Тэргүүлэх аудитор  
Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Наранбаяр  
Утас: 70543179  
Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Батсайхан  
Утас: 70543151  
Цахим хаяг: [batsaikhants@audit.gov.mn](mailto:batsaikhants@audit.gov.mn)

Хаяг: ГСА, Сүмбэр сум 3-р баг, Нутгийн  
удирдлагын ордон 2 давхар

## Аудитын тайлан

Агуулга

1. Аудитын гэрчилгээ
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан
4. Менежментийн захидал

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	3
2.1	Оршил .....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	<b>Error! Bookmark not defined.</b>
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .	<b>Error! Bookmark not defined.</b>
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	<b>Error! Bookmark not defined.</b>
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар..	<b>Error! Bookmark not defined.</b>
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал ....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	<b>Error! Bookmark not defined.</b>
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.12	Шилэн дансны мэдээлэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3	Менежментийн захидал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.1	«management_zurchil1» .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2	«management_zurchil2» .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	18
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	18
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	19

4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	21
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	24

## **1 Аудитын гэрчилгээ**

---

*Баталгаажуулсан гэрчилгээг скайннердаж оруулах*

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн аудитын тайланг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Аюушжавт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн “2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.03.15-наас 2018.03.25-ны хооронд хийж, аудитын тайланг 2018.03.25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018.03.12-ны өдрийн 86 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан” нь “Иргэд, даатгуулагчдад хөнгөн шуурхай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн даатгалын хүрээг өргөтгөх замаар тэдний тэтгэвэр, тэтгэмж авах, хуульд заасан бусад эрхээ бүрэн эдлэх таатай нөхцлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан” нь дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан” нь “Эерэг хандлага, чанартай үйлчилгээ” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2009 оны 396 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлийг хийлгээгүй байна.

Говьсүмбэр аймгийн "Нийгмийн даатгалын сан"-гийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд ЭМНДЕГ-ын Мэдээллийн технологийн газрын зохиосон програмыг 2006 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд програмын өөрчлөлтийг тухай бүрт нь хийлгэж ирсэн байна.

Аудитын явцад судалсан дотоод хяналтаар авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлага, өглөгийг санхүүгийн тайланд илүү, дутуу бүртгэж тайлагнасан, хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, шууд зардлаар тайлагнасан, НББ-ийн үйл

ажиллагааг аккумуляр сууриар бүртгээгүй зэрэг шат шатны хяналт сул байгаа тул дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 31 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 7 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 30 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 7 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгож материаллаг байдлыг 0.5%-иар тооцсонтой холбоотой юм.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 11,510.341.3 мянган төгрөг бөгөөд түүний 0.5% буюу 57,551.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.



Нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 26 эрсдэлтэй асуудалд 26 горим, сорил хэрэгжүүлж түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 85% буюу 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	4	336,547.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	334.1	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>336,881.2</b>	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 2 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа нэгтгэгддэг бөгөөд эдгээр байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Орлого үр дүнгийн тайланд үнэгүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийн орлого, лавлагааны орлого нийт 13,541.2 мянган төгрөгийг орлогын нэр төрлөөр ангилж тайлагнаагүй, туслах үйл ажиллагааны орлого нэрээр бөөн

дүнгээр тайлагнасан, мөн нэмэлт санхүүжилтийн орлого 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны нийт үр дүнгийн зардал хэсэгт тус тус тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг нэр төрлөөр нь үнэн зөв ангилж, тайлагнах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2. 2017 онд ажилчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгохдоо ХХОАТ-ыг 126.0 мянган төгрөгөөр дутуу суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан ХХОАТ-ыг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. 2016 онд ажлаас чөлөөлөгдсөн 2, тэтгэвэрт гарсан 1 ажилтанд тэтгэмж 13,166.8 мянган төгрөгийг олгохоор гарсан шийдвэрийн дагуу уг тэтгэмжийг 2017 оны төсөвт тусгуулан олгосон боловч тайланд өглөгөөр тусгаагүй, мөн тэтгэмжийг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.1.4, Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам”-ын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгөөр тусгаагүй 13,166.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ

4. Ажилчдын цалинг илүү, дутуу тооцож олгосон байна. Тухайлбал: 1 хүнд 28.1 мянган төгрөг дутуу, 3 хүнд 180.0 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгогдсон цалинг орон нутгийн орлогод төвлөрүүлэх, дутуу олгосон цалинг холбогдох ажилтанд буцаан олгуулах төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

5. Тайлант хугацаанд авлагыг 208,123.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тухайлбал: Байгууллагаас авах НДШ-ийн авлага 129,505.5 мянга, халаалтын авлага 1,015.8 мянга, улсын төсвөөс авах ЭМДС-гийн санхүүжилт 51,104.7 мянга, НДШ-ийн алдангийн авлага 5,349.4 мянга, НДШ-ийн актын авлага 9,630.4 мянга, хувь хүнээс авах авлага 11,517.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. 8 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дансны авлагыг барагдуулах арга хэмжээ зохион байгуулж өмнөх оны түвшингээс бууруулж ажиллах зөвлөмж өгөв.

6. Тайлант онд ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөөг 101,216.1 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Орлогын төлөвлөгөөг бодит тоо мэдээнд үндэслэн үнэн зөв төлөвлөж батлуулах, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд анхаарч байгууллагын нөөц бололцоог дайчлан ажиллах зөвлөмж өгөв.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

### **2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал**

2.9.1.1. 2017 онд ажилчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгохдоо 126.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

2.9.1.2. Ажилчдын цалинг олгохдоо 1 хүнд 28.1 мянган төгрөг дутуу, 3 хүнд 180.0 мянган төгрөг илүү тооцож олгожээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг тус тус зөрчжээ.

### **2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал гаргаагүй.**

### **2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гаргаагүй.**

### **2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гаргаагүй.**

#### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн, зөрчлийн нэгтгэл:**

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 336,881.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 334.1 мянган төгрөгийн акт тогтоож, 336,547.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг дахин гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-д өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой сангийн орлогын төлөвлөгөө 9,052.192.0 мянга, сан болон үйл ажиллагааны зарлагын төсвийг 10,909,677.8 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/мянган төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	10,909.677.8	10,574,991.2	98 %	334,686.6
1.1	Урсгал зардал	10,909,677.8	10,574,991.2	98 %	334,686.6
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	9,052.192.0	9,372,748.6	103.5%	320,556.6
2.1	Улсын төсвөөс санхүүжих				0.0
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,052,192,0	9,370.362.7	103.5%	318,170.7
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос		2,385.9		2,385.9

Тайлант онд сангийн орлогыг төлөвлөгөө анх 8,524.817.6 мянган төгрөгөөр батлагдсан боловч 3 удаагийн тодотголоор нийт 527,374.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 9,052,192.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Сангийн болон үйл ажиллагааны зарлагын төлөвлөгөөг анх 10,732.756.2 мянган төгрөгөөр баталж 3 удаагийн төсвийн тодотголоор 176,921.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, нийт 10,909.677.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Батлагдсан орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал

/мянган төгрөг/					
Д/д	Орлогын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	%-иар
1	Тэтгэвэрийн даатгалын сангийн орлого	5,410,707.4	5,679,085.6	268,378.2	4.96
2	Тэтгэмжийн даатгалын сангийн орлого	664,570.9	725,236.0	60,665.1	9.13
3	ҮОМШӨД-ын сангийн орлого	825,992.4	854,516.1	28,523.7	3.45
4	ЭМД-ын сангийн орлого	1,992,105.6	1,890,889.4	-101,216.2	-5.08
5	Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	158,815.7	201,271.3	42,455.6	26.73
<b>Нийт дүн</b>		<b>9,052,192.0</b>	<b>9,350,998.4</b>	<b>298,806.4</b>	<b>3.30</b>

Дээрх хүснэгтээс харахад: Сангийн орлого гүйцэтгэлээрээ 298,806.4 мянган төгрөгөөр давж биелсэн боловч нэр төрлөөрөө ЭМД-ын сангийн орлого 101,216.2 мянган төгрөг буюу 5.08%-иар тасарсан байна.

Нийгмийн даатгалын сангийн дансны чөлөөт үлдэгдэлд бодогдсон банкны хүүгийн орлого, алдангиас 623.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсан боловч гүйцэтгэлээр хүүгийн орлого 14,018.9 мянга, НДШ-ийн алдангийн

орлого 5,465.7 мянга, лавлагааны орлого 2,356.5 мянга нийт 21,841.1 мянган төгрөг төвлөрсөн байна

Сангийн болон үйл ажиллагааны зарлагын төсөв нийт 10,909.677.8 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр тэтгэвэрийн даатгалын сангийн зарлагад 7,437,854.4 мянга, тэтгэмжийн даатгалын сангийн зарлагад 683,430.2 мянга, ҮОМШӨД-ын сангийн зарлагад 312,059.8 мянга, ЭМД-ын сангийн зарлагад 1,595,468.3 мянга, ажилгүйдлийн даатгалын санд 321,024.8 мянга, шимтгэлийн буцаалтанд 253.6 мянга, үйл ажиллагааны зардалд 224,900.1 мянга, нийт 10,574,991.2 мянган төгрөгийг зарцуулж 334,686.6 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Тайланд онд урсгал үйл ажиллагааны зардлын хэмнэлт 3,133.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайланд хугацаанд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 616.3 мянга, эцсийн үлдэгдэл 877,042.7 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

2017 онд ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь 494,037.7 мянган төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй байснаас байгууллагаас авах НДШ-ийн авлага 129,505.5 мянга, улсын төсвөөс авах ЭМДС-гийн санхүүжилт 51,104.7 мянга, НДШ-ийн алдангийн авлага 5,349.4 мянга, НДШ-ийн актын авлага 9,630.6 мянга, халаалтын авлага 1,015.8 мянга, хувь хүнээс авах авлага 11,517.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 702,161.0 мянган төгрөгийн авлагыг үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайланд хугацаанд 9,777.0 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй байснаас төсвийн хөрөнгөөр 8,835.2 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,257.5 мянган төгрөгийн үнэт цаасны маягыг орлогоор бүртгэж, бараа материал нийт 10,092.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 7,644.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, оны эцэст 12,225.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

2017 онд 927,101.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байснаас НДЕГ-аас 9,897.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын А-5/3401 тоот албан бичгээр 19,472.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан данснаас хасаж, 917,527.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

2017 оны эхэнд 29,484.7 мянган төгрөгийн өглөгтэй байснаас үнэт цаасны өглөг 867.7 мянга, ЭМД-ын урьдчилж орсон орлого 326.3 мянга, нөхөн даатгалын шимтгэлийн өглөг 129.9 мянга, бусад өглөг 868.4 мянган нийт 2,192.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, ААНБ-ын НДШ-ийн өглөгийн илүү төлөлтөөс 3,976.6 мянга, Сайн дурын даатгалын урьдчилж орсон орлого 89.5 мянга НДШ-ийн өглөг 282.8 мянга, халаалтын өглөг 5,138.4 нийт 9,487.3 мянган төгрөгөөр хасагдаж 22,189.7 мянган төгрөгийг өглөгийг үлдэгдлээр тайлагнасан байна. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар ЭМНДЕГ-аас 500.0 мянган төгрөг олгосныг ажил олгогчийн зөвлөгөөн зохион байгуулах зардалд зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 26 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 26 горим сорил хэрэгжүүлэв.

Тус газар нь Шилэн дансны хуулийн дагуу нийт 298 мэдээлэх оруулахыг бүрэн оруулсан бөгөөд нийт оруулсан мэдээллийг 51.3% буюу 153 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитын явцад нийт 487.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12,412.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг дахин гаргахгүй байх, бодлогын түвшинд шийдвэрлүүлэх асуудлаар зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн актыг барагдуулж, зөвлөмжийн биелэлт 75%-тай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймгийн "Нийгмийн даатгалын хэлтсийн 2017.09.27-ны өдрийн 88 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан”-гийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын сан” -гийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно.

Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

